**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/95/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776<br>Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 10
5.1 Төлбөрийн акт ..... 10
5.2 Албан шаардлага ..... 11
5.3 Зөвлөмж ..... 11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02. 25 № 66

танай ________________-ны №________________ -т

ШАРЫН ГОЛ СУМЫН 6 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЭНХТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь Боловсролын газрын даргын 2025 оны 07 сарын 22-ны өдрийн 433 дугаар албан бичгийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлэхтэй холбоотой хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын бүтэц орон тоог 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/41 тушаалаар баталж үйл ажиллагаа эхэлсэн байна.

4526050171

**Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 6 дугаар сургууль нь 2025 онд 4 зорилт 57 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93.4 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **110,519,529.11** | **80,379,908.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 58,079,620.17 | 10,334,981.47 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 58,079,620.17 | 10,334,981.47 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 58,079,620.17 | 10,334,981.47 |
| **33** | **АВЛАГА** | - | 23,760.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 23,760.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 52,439,908.94 | 70,021,167.24 |
| **351** | **Түүхий эд материал** | 374,290.00 | 340,100.00 |
| 35130 | Эм боох материал | 374,290.00 | 340,100.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 52,065,618.94 | 69,681,067.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 739,500.00 | 1,075,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,872,058.54 | 57,908,258.54 |
| 35450 | Барилгын засварын материал | 170,000.00 | 4,734,950.00 |
| 35460 | Хүнсний материал | | 759,835.30 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,284,060.40 | 5,202,923.40 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,830,330,628.76** | **1,884,236,116.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,830,330,628.76 | 1,884,236,116.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,797,256,452.68 | 1,851,754,397.96 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,678,542,093.00 | 1,678,542,093.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (298,971,186.78) | (352,474,046.70) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 396,471,884.12 | 508,009,182.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (107,390,164.80) | (161,715,967.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 108,633,484.34 | 166,339,484.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,955,249.04) | (32,074,496.64) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 31,636,958.00 | 31,636,958.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (7,086,915.72) | (8,826,845.69) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,080,000.00 | 3,080,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (461,999.97) |
| 39217 | Ном | 21,295,549.56 | 19,700,037.08 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 33,074,176.08 | 32,481,718.14 |
| 39301 | Програм хангамж | 3,949,720.00 | 3,949,720.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (789,943.92) | (1,382,401.86) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,914,400.00 | 29,914,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,940,850,157.87** | **1,964,616,024.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2,491,919.51** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 2,491,919.51 |
| **413** | **Өглөг** | - | 2,491,919.51 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 2,491,919.51 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,940,850,157.87** | **1,962,124,105.30** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,940,850,157.87 | 1,962,124,105.30 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 223,226,469.55 | 223,226,469.55 |
| 51101 | Өмч: - төрийн | 223,226,469.55 | 223,226,469.55 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 321,082,670.87 | 342,356,618.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 321,082,670.87 | 321,082,670.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 21,273,947.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,396,541,017.45 | 1,396,541,017.45 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,940,850,157.87** | **1,964,616,024.81** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,501,584,530.60** | **1,863,045,440.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **114,166,730.60** | **230,942,440.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 114,166,730.60 | 230,942,440.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,193,112.00 | 37,100,329.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 654,800.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,538,312.00 | 27,871,329.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 9,229,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 102,602,805.20 | 172,769,473.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 3,370,813.40 | 21,072,638.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,387,417,800.00** | **1,632,103,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,188,557,800.00 | 1,412,153,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,188,557,800.00 | 1,412,153,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 198,860,000.00 | 219,950,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 198,860,000.00 | 219,950,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,548,333,413.68** | **1,839,398,407.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,548,333,413.68** | **1,839,398,407.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,500,783,112.68 | 1,789,811,316.09 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 996,692,745.25 | 1,201,671,490.14 |
| 210101 | Үндсэн цалин | 621,189,150.41 | 738,814,594.76 |
| 210102 | Нэмэгдэл | 330,966,441.03 | 393,015,584.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 35,381,408.03 |
| 210104 | Урамшуулал | 44,537,153.81 | 34,459,902.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,524,889.23 | 149,753,122.74 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,225,190.76 | 102,780,997.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,026,493.02 | 12,166,114.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,013,246.58 | 6,035,517.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,851,991.84 | 5,756,198.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,407,967.03 | 23,014,294.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 191,266,071.00 | 207,213,532.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,425,889.15 | 11,020,377.80 |
| 210302 | Түлш, халаалт | 169,849,057.00 | 184,011,595.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,991,124.85 | 12,181,559.26 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,953,799.19 | 17,781,575.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,243,450.00 | 516,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 570,000.00 | 450,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 52,800.00 | 194,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,087,549.19 | 9,270,838.40 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 7,349,637.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 173,910.00 | 139,690.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 173,910.00 | 139,690.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,200,200.00 | 15,184,050.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,200,200.00 | 15,184,050.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,772,670.81 | 15,747,377.33 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 654,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,117,870.81 | 15,747,377.33 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153,198,827.20 | 182,320,478.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,286,150.00 | 36,503,078.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,740,500.00 | 4,681,050.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 130,172,177.20 | 141,136,350.18 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,550,301.00 | 49,587,091.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,033,700.00 | 49,579,294.70 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,384,000.00 | 49,579,294.70 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,649,700.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 516,601.00 | 7,796.70 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 516,601.00 | 7,796.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(46,748,883.08)** | **23,647,033.11** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 5,722,248.40 | 2,373,085.68 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,722,248.40 | 2,373,085.68 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (5,722,248.40) | (2,373,085.68) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(52,471,131.48)** | **21,273,947.43** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,397,445,472.00** | **1,659,974,329.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,027,672.00** | **27,871,329.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,027,672.00 | 27,871,329.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,027,672.00 | 27,871,329.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 654,800.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,372,872.00 | 27,871,329.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,387,417,800.00** | **1,632,103,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,188,557,800.00 | 1,412,153,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,188,557,800.00 | 1,412,153,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 198,860,000.00 | 219,950,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 198,860,000.00 | 219,950,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,416,482,527.29** | **1,692,302,517.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,416,482,527.29** | **1,692,302,517.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,368,932,226.29** | **1,641,955,591.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 996,692,745.25 | 1,199,179,570.63 |
| 210101 | Үндсэн цалин | 621,189,150.41 | 736,852,577.95 |
| 210102 | Нэмэгдэл | 330,966,441.03 | 393,015,584.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 35,381,408.03 |
| 210104 | Урамшуулал | 44,537,153.81 | 33,930,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,524,889.23 | 149,776,882.74 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,225,190.76 | 102,780,997.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,026,493.02 | 12,166,114.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,013,246.58 | 6,041,477.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,851,991.84 | 5,758,158.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,407,967.03 | 23,030,134.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 191,266,071.00 | 207,213,532.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,425,889.15 | 11,020,377.80 |
| 210302 | Түлш, халаалт | 169,849,057.00 | 184,011,595.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,991,124.85 | 12,181,559.26 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,370,200.00 | 18,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,370,200.00 | 18,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,772,670.81 | 18,738,377.33 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 654,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,117,870.81 | 18,738,377.33 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,305,650.00 | 48,547,228.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,475,150.00 | 43,746,178.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,830,500.00 | 4,801,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,550,301.00** | **50,346,926.70** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,033,700.00 | 50,339,130.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,384,000.00 | 50,339,130.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,649,700.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 516,601.00 | 7,796.70 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 516,601.00 | 7,796.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(19,037,055.29)** | **(32,328,188.70)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23,935,400.00** | **15,416,450.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23,935,400.00** | **15,416,450.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23,935,400.00 | 15,416,450.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 18,475,400.00 | 15,416,450.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,460,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(23,935,400.00)** | **(15,416,450.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **(42,972,455.29)** | **(47,744,638.70)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **101,052,075.46** | **58,079,620.17** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **58,079,620.17** | **10,334,981.47** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 223,226,469.55 | 1,396,541,017.45 | 373,553,802.35 | 1,993,321,289.35 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **223,226,469.55** | **1,396,541,017.45** | **373,553,802.35** | **1,993,321,289.35** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (52,471,131.48) | (52,471,131.48) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **223,226,469.55** | **1,396,541,017.45** | **321,082,670.87** | **1,940,850,157.87** |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **223,226,469.55** | **1,396,541,017.45** | **321,082,670.87** | **1,940,850,157.87** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **223,226,469.55** | **1,396,541,017.45** | **321,082,670.87** | **1,940,850,157.87** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 21,273,947.43 | 21,273,947.43 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **223,226,469.55** | **1,396,541,017.45** | **342,356,618.30** | **1,962,124,105.30** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **58,079,620.17** | -32,328,188.70 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,494,629,400.00** | **1,487,768,967.70** | **28,048,211.30** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,494,629,400.00** | **1,487,768,967.70** | **28,048,211.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,438,331,700.00** | **1,437,429,837.70** | **22,089,641.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,201,302,000.00** | **1,199,179,570.63** | **2,122,429.37** |
| 210101 | Үндсэн цалин | 764,396,400.00 | 736,852,577.95 | 27,543,822.05 |
| 210102 | Нэмэгдэл | 429,073,500.00 | 393,015,584.65 | 36,057,915.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 35,381,408.03 | -35,381,408.03 |
| 210104 | Урамшуулал | 7,832,100.00 | 33,930,000.00 | -26,097,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **150,221,100.00** | **149,776,882.74** | **444,217.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,150,300.00 | 102,780,997.74 | -630,697.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,017,700.00 | 12,166,114.61 | -148,414.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,008,900.00 | 6,041,477.35 | -32,577.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,008,900.00 | 5,758,158.61 | 250,741.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,035,300.00 | 23,030,134.43 | 1,005,165.57 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,311,600.00** | **18,738,377.33** | **573,222.67** |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 19,311,600.00 | 18,738,377.33 | 573,222.67 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **67,497,000.00** | **69,735,007.00** | **18,949,772.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,779,500.00 | 64,933,957.00 | 17,033,322.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,717,500.00 | 4,801,050.00 | 1,916,450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,297,700.00** | **50,339,130.00** | **5,958,570.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,297,700.00 | 50,339,130.00 | 5,958,570.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,297,700.00 | 50,339,130.00 | 5,958,570.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,494,629,400.00 | **1,440,024,329.00** | **2,297,100.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,414,450,100.00 | **1,412,153,000.00** | **2,297,100.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,414,450,100.00 | 1,412,153,000.00 | 2,297,100.00 |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **80,179,300.00** | **27,871,329.00** | **-** |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,100,000.00 | 27,871,329.00 | |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 58,079,620.17 | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 58,079,620.17 | -58,079,620.17 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 10,334,981.47 | -10,334,981.47 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **274,711,300.00** | **225,713,532.30** | **48,997,767.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **274,711,300.00** | **225,713,532.30** | **48,997,767.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **274,711,300.00** | **225,713,532.30** | **48,997,767.70** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **256,211,300.00** | **207,213,532.30** | **48,997,767.70** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,627,200.00 | 11,020,377.80 | 6,606,822.20 |
| 21302 | Түлш халаалт | 218,198,800.00 | 184,011,595.24 | 34,187,204.76 |
| 21303 | Цэвэр, бохир ус | 20,385,300.00 | 12,181,559.26 | 8,203,740.74 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **18,500,000.00** | **18,500,000.00** | **-** |
| 210604 | Урсгал засвар | 18,500,000.00 | 18,500,000.00 | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **270,946,500.00** | **219,942,203.30** | **51,004,296.70** |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **3,764,800.00** | **5,771,329.00** | **(2,006,529.00)** |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,764,800.00 | 5,771,329.00 | (2,006,529.00) |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,315.9 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулаа. Үүнд:

1. Тайлант онд 3,315.9 мянган төгрөгийн бараа материалын ангиллыг буруу тайлагнасан нь “*УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*", *“Санхүүгийн тайлангийн толилуулга”* батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнгийн дансанд бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 7,818.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэн тул 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын Гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлээгүй байхад захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч сургалтын менежер Б.Энхтуяад 2,494,600.00 төгрөгийн, сургалтын менежер Н.Алтанцацралд 2,463,400.00 төгрөгийн, нийгмийн ажилтан А.Рисгүльд 2,260,700.00 төгрөгийн улирал бүр үр дүнгийн урамшуулал, нийт 7,218,700.00 төгрөгийг дээд байгууллагын шийдвэргүй олгож, төсвийг үр ашиггүй

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2-т "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", 39.1.3-т "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд тус сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Б.Энхтуяагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д ““Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын ангиллыг буруу тайлагнасан | 1 | 3,315.9 | - | - | 1 | 3,315.9 | 1 | 3,315.9 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **3,315.9** | **-** | **-** | **1** | **3,315.9** | **1** | **3,315.9** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| **Зөрчлийн товч утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | |
| Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан. | 1 | 600.0 | 1 | 600.0 | - | - | - | - | - | - | |
| Байгууллагын Гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлээгүй байхад захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч сургалтын менежер Б.Энхтуяад 2,494,600.00 төгрөгийн, сургалтын менежер Н.Алтанцацралд 2,463,400.00 төгрөгийн, нийгмийн ажилтан А.Рисгүльд 2,260,700.00 төгрөгийн улирал бүр үр дүнгийн урамшуулал, нийт 7,218,700.00 төгрөгийг дээд байгууллагын шийдвэргүй олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан | 1 | 7,218.7 | 1 | 7,218.7 | - | - | - | - | - | - | |
| **Дүн** | **2** | **7,818.7** | **2** | **7,818.7** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |